



**АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/304

Улаанбаатар хот

Үйлчилгээний үнэ, хөлсний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх заалт, Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журмын 3.2, 3.3, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 7.1, 11.1, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 55 дугаар тогтоолоор батлагдсан "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын дүрмийн 6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Мэргэшсэн жолоочийн шалгалтын үйлчилгээний үнэ, хөлсийг 9000 /есөн мянга/ төгрөгөөр тогтоож мөрдсүгэй.
2. Батлагдсан үнэ дээр нэмэгдсэн өртгийн албан татварын 10 хувийг нэмэгдүүлэн тооцож, орлогын мөнгийг тусгайлан даанс нээн бүртгэж, тайланд тусгахыг Санхүү эдийн засгийн хэлтэс /Я.Оюунсүрэн/-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тээвэр зохицуулалтын хэлтэс /Д.Батбаяр/-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Үйлдвэрийн газрын захирлын 2014 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 69 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



П.ДӨЛГЭРНАРАН